



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/273

Улаанбаатар хот

Г

Журам шинэчлэн батлах тухай

Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 7.1.5 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 78 дугаар тогтоолын 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалт”-ыг нэгдүгээр, “Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг хоёрдугаар, “Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах орон тооны бус зөвлөлийн ажиллах журам”-ыг гуравдугаар, “Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэдэд эмнэлгийн дүгнэлт гаргах маягт”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчин, эмгэгийн улмаас гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчилгээ хийлгэх иргэдэд дүгнэлт гаргах орон тооны бус комисс байгуулж, үйл ажиллагааг нь удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн захирал нарт үүрэг болгосугай.

3. Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний жагсаалтаас хасагдсан эмчилгээ болон цаашид багасгахад чиглэсэн шинэ технологи нэвтрүүлэх, бэхжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, хүний нөөцийг бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (А.Өнөржаргал), Бодлого төлөвлөлтийн газар (П.Оюунцэцэг), Санхүү, эдийн засгийн газар (Л.Лувсан), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

5. Тушаал шинэчлэн батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/370, 2018 оны А/206, 2021 оны А/322 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



С. ЧИНЗОРИГ

141240805

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
06 сарын 07 өдрийн 7/12 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСАД ЭМЧЛЭХ БОЛОМЖГҮЙ ӨВЧНИЙ ЖАГСААЛТ

Өвчний нэр, эмчилгээний нэр төрөл			
Д/д	Монголоор	Оросоор	Англиар
А.	Мэдрэлийн мэс засал	Нейрохирургия	Neurosurgery
1.	Тархи нугасны гүний, төвөгтэй байрлалтай, нэвчсэн, мэс заслаар авах боломжгүй болон бусад ажилбар эмчилгээ шаардагдах хавдар, хавдар төст эмгэгийн мэс засал, эмчилгээ	Неоперабельная опухоль и опухольподобные болезни с глубинной локализацией головного и спинного мозга, но требующие другие варианты вмешательств и лечение	Surgery and treatment of deep, complicated, infiltrated, unresectable tumors and tumor-like disease of the brain and spinal cord
2.	Паркинсоны өвчин, торсион дистонид стереотакс мэс заслын аргаар тархины гүнийн өдөөлт хийн, электрод суулгах эмчилгээ	Глубокая мозговая стимуляция методом стереотаксической хирургии имплантация электрода при болезни Паркинсона и торсионной дистонии	Treatment of Parkinson's disease and torsion dystonia with stereotactic procedures such as deep brain stimulation and implantation of electrical stimulators
Б.	Чих хамар хоолой судлал	Оториноларингология	Otorhinolaryngology
3.	Сонсголын мэдрэлийн хавдрын үеийн мэс засал	Опухоль слухового нерва	Surgery for Acoustic neuroma
4.	Вегенерийн өвчний хүнд хэлбэрийн үеийн эмчилгээ	Лечение тяжелой формы болезни Вегенера	Treatment of severe Wegener's disease
5.	Меньерийн өвчний хүнд хэлбэрийн үеийн мэс засал эмчилгээ	Хирургическое лечение тяжелой формы болезни Меньера	Surgery treatment for severe Meniere's disease
В.	Зүрх, судасны мэс засал	Кардиоваскулярная хирургия	Cardiovascular surgery
6.	Зүрхний титэм судасны хүнд хэлбэрийн нарийсал, судасны дисплази эмчилгээ	Лечение тяжелой степени сужения коронарного сосуда и дисплазии сердца	Treatment of severe coronary artery stenosis and vascular dysplasia
7.	Хүүхдийн хавсарсан хөх, хүнд хэлбэрийн зүрхний төрөлхийн гажгийн үеийн мэс засал эмчилгээ	Хирургическое лечение тяжелых форм врожденных синих и комбинированных пороков сердца	Surgical treatment of pediatric severe, cyanotic congenital heart disease
8.	Гол судасны хүнд хэлбэрийн цүлхэн, хуулралын эмчилгээ	Лечение тяжелых форм аневризмы и расслоения аорты	Treatment of severe aortic aneurysm and dissection
9.	Зүрхний хавхлагуудын өөрчлөлт, кардиомиопати, зүрхний хүнд хэлбэрийн хэм алдагдлын улмаас	Лечение при снижении сердечного выброса на 25% и ниже вследствие	Treatment of valvular heart disease, cardiomyopathy and

	зүүн ховдлын агших чадвар 25 хувиас доош болсон тохиолдлын эмчилгээ	изменений клапанов, кардиомиопатии и тяжелых форм аритмии сердца	cardiac arrhythmia in patients with reduced ejection fraction below 25%
10.	Хүүхдийн зүрхний хэм алдагдлын үеийн электрофизиологийн оношилгоо, эмчилгээ	Электрофизиологические методы диагностики и лечения при аритмии сердца у детей	Electrophysiological diagnosis and treatment of pediatric cardiac arrhythmia
Г.	Хавдар судлал	Онкология	Oncology
11.	Толгой хүзүүний өргөтгөсөн мэс заслын дараах согог, эрхтнийг хиймэл эрхтэн буюу протезоор орлуулах (хиймэл төвөнх), нармайн хавдрын мэс заслын эмчилгээ	Протезирование функционального дефицита и анатомического дефекта после расширенной хирургии рака головы и шеи, Хирургическое лечение рака носоглотки	Prosthesis of functional deficit and anatomical defect after extended surgery of head and neck cancers, surgical treatment of nasopharyngeal cancer
12.	Эгмээс дооших цагаан мөгөөрсөн хоолойн хавдрын мэс заслын эмчилгээ	Хирургическое лечение рака трахеи в полости грудной клетки	Surgical treatment of thoracic tracheal cancer
13.	Яс, зөөлөн эдийн хавдрын нөхөн сэргээх мэс засал: - Бага аарцаг, цээжний хананы байрлалтай хорт хавдар	Реконструктивная хирургия мягких тканей и костей: - Злокачественные новообразования стенки грудной клетки и малого таза	Reconstructive surgery of soft tissue and bone cancer: - Cancer of pelvis and thoracic wall
14.	Тархи нугасны хавдрууд, толгой хүзүүний дахисан хавдрын стериотактик туяа эмчилгээ	Стереотактическая лучевая терапия при опухолях головного и спинного мозга и при рецидивирующих опухолях головы и шеи	Stereotactic radiation therapy of brain, spinal cord and recurrent head and neck cancers
Д.	Уушги судлал	Пульмонология	Pulmonology
15.	Уушгины төрөлхийн гажгийн мэс заслын эмчилгээ	Хирургическое лечение врождённых патологий легких	Surgical treatment of congenital pulmonary disorders
Е.	Гэмтэл согог судлал	Травматология и ортопедия	Traumatology and orthopedics
16.	Дээд болон доод мөчдийн төрөлхийн хүнд хэлбэрийн дутуу хөгжил, гэмтлийн мэс засал	Хирургическое лечение травм, врожденных аномалии развития верхней и нижней конечностей	Surgical treatment of severe form of congenital amelia or hemimelia of limbs
17.	Хүзүү, сээр, бүсэлхий нурууны нугас тасарсан хүнд гэмтлийн үеийн мэс засал	Хирургическое лечение тяжёлых форм травм шейного, грудного и поясничного отделов позвоночника с синдромом повреждения спинного мозга	Surgical treatment of severe cervical, thoracic, and lumbar spinal cord trauma

18.	Хүзүү, сээр, бүсэлхий нурууны төрөлхийн хүнд хэлбэрийн мурийлт эмгэгийн мэс засал	Хирургическое лечение врождённого шейного, грудного и поясничного сколиоза	Surgical treatment of congenital severe scoliosis of cervical, thoracic and lumbar spine
Ё.	Эрхтэн шилжүүлэн суулгах	Трансплантация органов	Organ transplantation
19.	Донороос реципентэд ясны чөмөг шилжүүлэн суулгах	Трансплантация костного мозга от донора реципиенту	Allogeneic hematopoietic stem cell transplantation
20.	Зүрх, нойр булчирхай, гэдэс, уушги шилжүүлэн суулгах	Трансплантация сердца, поджелудочной железы, кишечника и лёгких	Heart, pancreas, bowel, and lung transplantation
21.	Элэг шилжүүлэн суулгах дараах тохиолдолд: - артер, венийн судас болон цөсний замын анатомийн хэвийн бус бүтэцтэй, - резус бүлгийн үл тохирол, - 2 өөр донороос элэг шилжүүлэн суулгах.	Трансплантация печени в следующих случаях : - Абнормальное анатомическое развитие артериальных, венозных сосудов и желчных протоков, - Несовместимость резус фактора, - Трансплантация печени от 2 доноров	In the following cases of liver transplantation: - Atypical anatomical variations of hepatic artery and bile ducts - RH incompatibility - Dual living donor liver transplantation
22.	Тунгалгийн судасны гаж хөгжлийн нөхөн сэргээх мэс засал /Зааны хөл гэмээр өөрчлөлт/	Реконструктивно-пластические операции при лимфедеме (схожий со Слоновой ногой)	Elephantiasis reconstructive surgery of lymphatic malformations (Lymphatic filariasis, Elephantiasis)
Ж.	Эх барих, эмэгтэйчүүд, үргүйдэл судлал	Акушерство, гинекология, бесплодие	Obstetrics, gynecology and infertility
23.	Эмэгтэйчүүдийн бэлэг эрхтний гаж хөгжлийн үе дэх нөхөн сэргээх мэс засал	Пластическая операция при врождённых аномалиях развития женских репродуктивных органов	Reconstructive surgery for congenital malformation of female genital
24.	Ихэр жирэмсний үед ургаас урагт цус юүлэгдэх хам шинжийн үеийн лазер эмчилгээ	Внутриматочная лазерная абляция сосудистых анастомозов при фето-фетальном трансфузионном синдроме при беременности близнецами	Laser ablation of twin-twin transfusion syndrome (TTTS)
25	Үр хөврөлийг умайд суулгахаас өмнөх генетикийн оношилгоо	Преимплантационная генетическая диагностика	Preimplantation Genetic Diagnosis (PGD)

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
06-р сарын 09 өдрийн 4-дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГААР ГАДААД УЛСАД ЭМЧЛҮҮЛСЭН ИРГЭДЭД
САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АСУУДЛААР САНАЛ ГАРГАХ ОРОН ТООНЫ
БУС ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:	Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
Зөвлөлийн дэд дарга:	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын Лавлагаа шатлалын тусламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Санхүүжилтийн тооцоолол хариуцсан нарийн бичгийн дарга:	Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын Санхүү даатгалын хэлтсийн Яамны ахлах нягтлан бодогч
Гишүүд:	Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга
	Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч
	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал
	Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Эмнэлзүй хариуцсан дэд захирал
	Улсын гуравдугаар төв эмнэлгийн Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал
	Хавдар судлалын үндэсний төвийн Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал
	Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Эмнэлзүй хариуцсан дэд захирал
	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал
	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах албаны дарга

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
06 сарын 02 өдрийн 214 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГААР ГАДААД УЛСАД ЭМЧЛҮҮЛСЭН ИРГЭДЭД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АСУУДЛААР САНАЛ ГАРГАХ ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

- 1.1. Энэ журам нь Эрүүл мэндийн яамны дэргэдэх гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлсэн Монгол Улсын иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Зөвлөлийн ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хурал байна. Хурлыг гишүүдийн ирц 75 хувиас дээш тохиолдолд хүчинтэйд тооцох ба зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд оролцох боломжгүй тохиолдолд тухайн гишүүний ажил үүргийг орлон гүйцэтгэж байгаа албан тушаалтан оролцоно.
- 1.3. Зөвлөл нь журмын 2.4.1-д заасан материалыг бүрдүүлж ирүүлсэн иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг хэлэлцэн, олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 1.4. Зөвлөл нь 2 сар тутамд 1 удаа хуралдах ба шаардлагатай үед зөвлөлийн даргын шийдвэрээр хуралдана. Хурлыг зөвлөлийн дарга, түүний эзгүйд болон зөвшөөрлөөр дэд дарга даргална.
- 1.5. Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн иргэн эмчилгээний сүүлийн өдрөөс хойш 3 сарын дотор санхүүгийн дэмжлэг хүссэн хүсэлтээ, нотлох баримтын хамт эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.
- 1.6. Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалт, зөвлөлийн ажиллах журам, санхүүгийн дэмжлэг хүсэхэд бүрдүүлэх материал болон бусад тайлбар мэдээллийг Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд ил тод байршуулна.

Хоёр. Зөвлөлийн үүрэг:

- 2.1. Зөвлөл нь хууль дээдлэх, төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахих, шударга ёс, хариуцлага хүлээх зарчмын хүрээнд хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, хурлаар хэлэлцүүлж байгаа дэмжлэг хүссэн иргэн бүрийн материалд нийцсэн нэгдсэн шийдвэр гаргаж, Эрүүл мэндийн сайдад дэмжлэг үзүүлнэ.
- 2.2. Зөвлөлийн дарга нь гадаад эмчилгээний санхүүгийн зарцуулалтын тайланг хагас жил тутам Эрүүл мэндийн сайдын зөвлөлд танилцуулна.
- 2.3. Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн төрийн албан хаагчдын материалыг хэлэлцэн, шийдвэрийг харьяалагдах төсвийн захирагчид албан бичгээр хүргүүлнэ.

2.4. Гадаад эмчилгээний асуудал хариуцсан нарийн бичгийн дарга:

2.4.1. Гадаад эмчилгээний зардалд санхүүгийн дэмжлэг хүссэн иргэний материалыг шалган, санхүүжилтийн тооцоолол хариуцсан нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө. Иргэний бүрдүүлэх материалд дараах баримт бичгүүд хамаарна. Үүнд:

2.4.1.1.иргэний өөрийн болон асран хамгаалагч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өргөдөл;

2.4.1.2.иргэний үнэмлэх, хүүхэд бол төрсний гэрчилгээний хуулбар;

2.4.1.3.Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчнөөр гадаад улсад эмчлүүлэх шаардлагатайг эмчлүүлэхээс өмнө тодорхойлсон төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн гадаад эмчилгээний комиссын дүгнэлт эх хувиар;

2.4.1.4.гадаад улсад эмчилгээнд хамрагдсан эмнэлгийн дүгнэлт, төлбөр төлсөн баримтын эх хувиар (Англи хэлнээс бусад хэлээр бичигдсэн бол баталгаат орчуулгаар Монгол хэл рүү орчуулах);

2.4.1.5.насанд хүрэгчид нь сүүлийн 5-аас доошгүй жил эрүүл мэндийн даатгалд тасралтгүй даатгуулсныг нотлох баримт (хөдөлмөрийн чадвар алдалтаа тодорхойлуулсан иргэн нотлох баримтыг хавсарна);

2.4.1.6.эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд явж буй иргэдийн хувьд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албанаас авсан тодорхойлолт.

2.4.1.7.төрийн албан хаагчид ажиллаж байгаа байгууллагын тодорхойлолт.

2.4.2. Хурлын хөтөлбөрийг зөвлөлийн даргаар батлуулан, зөвлөлийн бүрэлдэхүүнд хурлын тов, хурлаар хэлэлцүүлэх иргэдийн нэгдсэн мэдээллийг ажлын 3 хоногийн өмнө тараана.

2.4.3. Хурлын протоколыг ажлын 3 хоногийн дотор зөвлөлийн дэд дарга, зөвлөлийн дарга нараар хянуулан албажуулна.

2.4.4. Эрүүл мэндийн байгууллагуудаас гаргасан Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалтад багтсан өвчнийг эх орондоо нутагшуулахад чиглэсэн судалгаа, санал санаачилгыг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, Эрүүл мэндийн яамны удирдлага, холбогдох газар, хэлтсийг мэдээллээр хангана.

2.4.5. Хурлаар хэлэлцүүлсэн иргэдийн материалын архивын нэгжийг бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгнө.

2.5. Гадаад эмчилгээний санхүүжилтийн тооцоолол хариуцсан нарийн бичгийн дарга:

2.5.1. Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн иргэний эмчилгээний төлбөр төлсөн баримтад үндэслэн тооцоолол гаргах ба сүүлийн гүйлгээний өдрийн Монгол банкны гадаад валютын албан ханшаар төгрөгт хөрвүүлэн эмчилгээнд

зарцуулсан нийт зардлаас насанд хүрэгчдэд 20 хувь, хүүхдэд 50 хувийг үндэсний мөнгөн тэмдэгтээр тооцон, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын даргаар хянуулж, зөвлөлийн хуралд танилцуулна.

2.5.2. Хурлын шийдвэрийн дагуу иргэдэд мөнгийг шилжүүлэх бэлтгэл ажлыг ханган, холбогдох журмын дагуу 5 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

2.5.3. Гадаад эмчилгээний санхүүжилтийн асуудлаар Зөвлөлийн даргыг мэдээллээр хангана.

Гурав. Зөвлөлийн гишүүний эрх, үүрэг:

3.1. Зөвлөлийн хуралд идэвхтэй оролцож санал, дүгнэлт гаргана.

3.2. Гадаад улсад эмчлүүлэхээр хандсан иргэдийг үнэн зөв мэдээллээр хангана.

3.3. Шаардлагатай тохиолдолд иргэнээс гадаад улсад хийгдсэн оношилгоо, эмчилгээний талаар тодруулга материалыг гаргуулна.

3.4. Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн иргэдэд эмнэлгийн дүгнэлт гаргах маягыг иргэнд нэг өвчний оношоор нэг удаа олгоно.

3.5. Эрүүл мэндийн технологийн чиглэл, бодлогын дагуу өөрсдийн эмнэлгийн нөөц бололцоонд тулгуурлан, орчин үеийн эмчилгээний технологийг нэвтрүүлэх, нутагшуулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дөрөв. Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэдэд эмнэлгийн дүгнэлт гаргах үйл ажиллагаа

4.1. Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төвд зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд дүгнэлт гаргах орон тооны бус комисс (цаашид “комисс” гэх) ажиллах бөгөөд тухайн байгууллагын захирлын тушаалаар баталгаажуулсан байна.

4.2. Комиссыг тухайн эрүүл мэндийн байгууллагын эмнэлзүй (эмчилгээ) эрхэлсэн дэд захирал, тасгийн эрхлэгч нарын бүрэлдэхүүнтэй байгуулна.

4.3. Комиссын ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хурал байна. Хурлын ирц 90 хувиас дээш тохиолдолд дүгнэлтийг хүчинтэйд тооцно.

4.4. Комисс нь Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалт”-д орсон өвчин болохыг нотлон дүгнэлт гаргана. Дүгнэлт гаргах үйл ажиллагаанд эмчлэгч эмч, төрөлжсөн мэргэшлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг татан оролцуулж болно.

4.5. Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх дүгнэлтийг төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг, онош, түүнийг баталгаажуулсан лабораторийн болон багажийн шинжилгээний хариуг үндэслэн комиссын хурлаар хариуцагч эмч хэлэлцүүлж, хамтын шийдвэр гаргана.

4.6. Комиссын хурлын шийдвэрийг дүгнэлт гаргах батлагдсан маягтын дагуу хоёр хувь үйлдэх ба өвчний заалт, оношийг бүрэн гүйцэд, тодорхой тусгаж, зөвлөгөөнд оролцсон эмч нар гарын үсгээ зурж, комиссын даргаар баталгаажуулан иргэнд нэг хувийг хүлээлгэн өгнө.

4.7. Комиссын нарийн бичиг нь зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн иргэдийн овог нэр, өвчний заалт, оношийн талаар хагас, бүтэн жилийн тайлан гаргаж, даргаар баталгаажуулан, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах орон тооны бус зөвлөлийн асуудал хариуцсан нарийн бичигт ирүүлнэ.

4.8. Иргэн өөрийн хүсэлтээр гадаад улсад эмчлүүлэхээр гаргасан хүсэлт энэ журамд хамаарахгүй.

Тав. Хүлээлгэх хариуцлага

5.1. Энэ журмаар тогтоосон хэм хэмжээ болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн албан тушаалтныг Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.2. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, энэ журмаар тогтоосон хэм хэмжээг илт хууль бусаар зөрчсөний улмаас байгууллага, иргэнд хохирол учруулсан гэм буруу нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй бол уг албан тушаалтныг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулна.

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
06 сарын 07 өдрийн 7/23 дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

**ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГААР ГАДААД УЛСАД ЭМЧЛҮҮЛЭХ ИРГЭДЭД
ЭМНЭЛГИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ МАЯГТ**

..... он сар өдөр

Эмнэлгийн байгууллагын нэр:

Хүн ам зүйн ерөнхий мэдээлэл:

Ургийн овог:

Эцэг, эхийн нэр: Өөрийн нэр:

Төрсөн он, сар, өдөр:

Нас:

Хүйс:

Регистрийн дугаар

Боловсрол:

Хөдөлмөр эрхлэлт:

Оршин суугаа хаяг:

Утас

Эрүүл мэндийн ерөнхий мэдээлэл:

Өндөр (см) Жин (кг)

Цусны даралт Судасны цохилт.....

Одоогийн өвчний түүх:

.....
.....
.....

Шинжилгээнүүд:

.....
.....
.....

Дүрс оношилгооны шинжилгээ:

.....
.....
.....

Эмнэлзүйн онош:

.....
.....

Зөвлөлийн шийдвэр (жагсаалтад байгаа өвчний онош, эмилгээний заалтыг бичнэ)

.....
.....
.....

Тамга:

Зөвлөлийн дарга/ /

Зөвлөлийн гишүүд 1. / /

2. / /

3. / /

Эмчлэгч эмч/ /

Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний онош, эмчилгээний
заалтаар эмчлүүлсэн эсэх /эмчилгээ хийлгэсэн эмнэлгийн дүгнэлтийг үндэслэх/
.....

Тамга:

Зөвлөлийн дарга/ /